

## МОНГОЛЫН БОЛОВСРОЛ ДАХЬ ЖЕНДЕРИЙН АСУУДАЛ: СУДАЛГААНЫ ДҮН

### Нэг. Оршил

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн энэ түүхэн зурвас үед боловсрол дахь хүйс /жендер/-ийн тэгш биш байдал ихээхэн газар авч байгаа ба энэ нь бодлогоор зохицуулах хэмжээнд хүрч гүнзгийрээд байна. Хүйсийн тэнцвэртэй байдал нь тухайн улсын хөгжлийг хангах нэгэн чухал хүчин зүйл болдогийнхоо хувьд боловсролын салбарыг нийгмийн тэргүүлэх салбар гэж үзэж байгаа манай улсын хувьд боловсролын салбар дахь хүйсийн тэгш бус харьцаа жил ирэх тутам нэмэгдэж байгаа явдал бидний анхаарлыг зүй ёсоор татаж байгаа юм.

ЮНЕСКО-гийн захиалгат санхүүжилтээр манай боловсролын салбар дахь хүйсийн тэгш бус харьцааны асуудлыг Боловсролын хүрээлэн судалж үзсэн бөгөөд судалгаанд нийт 600 сурагч, эцэг эх, багш, удирдах ажилтан хамрагдсан юм. Энэхүү судалгааны дүнг та бүхэнд танилцуулахын өмнө Монгол улс дахь хүйсийн харьцааны асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Өнөөдөр манай орны боловсрол дахь хүйсийн тэгш биш байдлыг авч үзэхдээ манай орны хүн амын хүйсийн харьцаанд гарсан өөрчлөлтүүдээс ангид авч үзэх боломжгүй юм. Жишээ нь 1918 оноос хойш манай оронд явагдсан хүн амын тооллогоос харахад, 1944 оны тооллогоос өмнө эрэгтэйчүүдийн тоо давамгайлж байсан нь харагдаж байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь тухайн үед эмэгтэйчүүдийн нас баралт өндөр эсвэл тооллогод эмэгтэйчүүд бүрэн хамрагдаж чадаагүйтэй холбоотой гэж судлаачид үзэж байгаа юм /Хүснэгт 1, диаграмм 1/.


Хүснэгт 1.

**Монгол улсын хүйсийн харьцаа, эмэгтэйчүүдийн эзлэх хувь  
/1918-2000 онд явагдсан хүн амын тооллогоор/**

Он	Хүн ам '000	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Хүйсийн харьцаа /эрэгтэйчүүд/100 эмэгтэйчүүд/
1918	647.5	49.0	104.1
1935	738.2	49.8	100.9
1944	759.1	51.1	95.7
1956	845.5	50.3	98.8
1963	1017.1	50.0	99.8
1969	1197.6	50.1	99.5
1979	1595.0	49.9	100.4
1989	2044.0	50.1	99.7
2000	2373.5	50.4	98.5

Диаграмм 1.

**Хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь  
/1918-2000 оны тооллогоор/**



Диаграммаас харвал 1989-2000 онуудад эмэгтэйчүүд дахин давамгайлж эхэлсэн нь харагдаж байгаа бөгөөд үүний нэг шалтгаан нь эрэгтэйчүүдийн нас баралт өндөр байсантай холбож үзэж байгаа юм.

1989, 2000 онуудад улсын хэмжээнд явагдсан тооллогыг авч үзэхэд 10-аас доош насны хүн ам хотод 27,5 хувиас 19,8, хөдөөд 31,8 хувиас 25,8 хувь хүртэл буурсан тоо гарсан байна. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд манай оронд төрөлт багасч байгаа нь харагдаж байгаа юм. Гэсэн хэдий ч өсвөр насны хүн амын /10-19 нас/ эзлэх хувийн жин хотод 23,4 хувиас 24,9 хувь, хөдөөд 23,3 хувиас 24,0 хувь хүртэл өссөн тоо байгаа юм. Үүнээс харахад манай оронд өнөөдөр хот, хөдөөд хүн амын бараг дөрөвний нэгийг өсвөр насны хүүхэд, залуучууд эзэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл манай хүн амын дөрөвний нэг болсон энэ өсвөр үеийхэн маань боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаа үндсэн бүрэлдэхүүн болж байгаа юм.

Хүйсийн байдлаар авч үзэх юм бол /Хүснэгт 2, диаграмм 2/ 10-аас доош насны хотын эрэгтэй хүүхдийн эзлэх хувь дээрхи хоёр тооллогын хооронд 28,1% байснаа 20,4 хувь хүртлээ буурсан байна. Хотын өсвөр насны хүүхэд, залуучуудын хувьд эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 23,3 хувиас 25,1 болж, эмэгтэйчүүдийнх нь 23,5 хувиас 24,6 хувь болж өссөн байна. Хөдөөд энэ насны эрэгтэй хүүхдийн хувьд ч мөн адил 31,8 хувиас 25,9 хувь болж буурсан нь харагдаж байна. Хөдөөд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 24,1 хувиас 24,6 хувь, эмэгтэйчүүдийнх 22,4 хувиас 23,3 хувь болж өсчээ.

Хот, суурин газар амьдарч буй хүн амын дотор 1989,2000 оны хооронд 10-14, 30-34, 40-44 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин нэмэгдсэн нь мөн ажиглагдаж байгаа бол /Диаграмм 2/ хөдөөд 20-54 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин нэмэгдсэн нь ажиглагдаж байна /диаграмм 3/


Хүснэгт 2.

**Хүн амын нас, хүйсийн бүтэц, хот хөдөөгөөр  
/1989,2000 оны тооллогоор/**

Насны бүлэг	Хот				Хөдөө				Бүгд			
	Эрэгтэй		Эмэгтэй		Эрэгтэй		Эмэгтэй		Эрэгтэй		Эмэгтэй	
	1989	2000	1989	2000	1989	2000	1989	2000	1989	2000	1989	2000
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
0-4	14.9	8.6	15.2	8.9	14.7	8.3	17.2	12.7	17.2	12.7	17.2	12.7
5-9	12.6	11.2	12.9	11.5	12.4	10.9	14.6	13.2	14.7	13.2	14.5	13.1
10-14	11.7	13.4	11.8	13.7	11.6	13.1	13.6	13.4	13.7	13.4	13.5	13.3
15-19	11.7	11.5	11.5	11.4	11.9	11.5	9.7	10.6	10.4	11.2	8.9	10.0
20-24	10.1	10.1	9.9	10.0	10.4	10.1	8.9	9.7	9.1	10.0	8.6	9.5
25-29	9.7	9.3	9.5	9.3	9.8	9.4	7.6	8.8	7.7	9.0	7.6	8.7
30-34	7.4	8.4	7.4	8.3	7.3	8.6	5.7	7.2	5.6	7.3	5.7	7.1
35-39	5.1	7.1	5.2	8.0	5.0	8.2	3.7	6.2	3.7	6.2	3.8	6.2
40-44	3.8	5.9	3.9	5.9	3.6	5.9	3.0	4.6	2.9	4.6	3.0	4.7
45-49	3.3	3.8	3.5	3.8	3.1	3.8	3.4	3.1	3.4	3.0	3.4	3.3
50-54	2.6	2.6	2.6	2.6	2.4	2.6	2.9	2.2	2.9	2.0	3.0	2.4
55-59	2.2	2.3	2.2	2.3	2.2	2.2	2.8	2.5	2.7	2.4	2.9	2.6
60-64	1.6	1.6	1.5	1.6	1.7	1.6	2.0	2.0	2.0	1.9	2.0	2.0
65-69	1.3	1.4	1.2	1.2	1.4	1.5	1.8	1.7	1.6	1.5	2.0	1.8
70-74	0.9	0.8	0.8	0.7	1.1	0.9	1.3	0.9	1.1	0.8	1.6	1.0
75+	1.1	1.0	0.9	0.8	1.4	1.3	1.8	1.2	1.3	0.8	2.3	1.6


Диаграмм 2.

**Хотын хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь /насны бүлгээр, 1989,2000 оны тооллогоор/**



Диаграмм 3.

**Хөдөөгийн хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь /насны бүлгээр, 1989,2000 оны тооллогоор/**



Хүйсийн харьцааг хүн амын насны бүлгээр авч үзвэл /Хүснэгт 3, диаграмм 4,5/ 1989 онд хорь хүртэлх насны хүүхэд, залуучуудын хүйсийн харьцаа өндөр байгаагаас гадна 35-54 насанд хүйсийн харьцаа мөн л 100-аас давж байна. 2000 оны тооллогоор хорин тав хүртэлх насны хүүхэд залуучуудын дунд эрэгтэйчүүд давамгайлж байгаа боловч 25 наснаас эхлээд эмэгтэйчүүдийн тоо давж эхэлж байгаа нь харагдаж байна.


Хүснэгт 3.

**Хүйсийн харьцаа насны бүлгээр, байршлаар /1989, 2000 оны тооллогоор/**

Насны бүлэг	Хот		Хөдөө		Бүгд	
	1989	2000	1989	2000	1989	2000
0-4	102.2	100.1	101.7	103.1	102.0	102.4
5-9	102.4	101.3	102.6	103.0	102.5	102.1
10-14	100.6	99.3	102.8	102.6	101.6	100.7
15-19	94.9	94.7	117.9	114.7	103.2	102.5
20-24	93.7	94.7	107.5	108.3	98.9	100.3
25-29	95.4	95.2	101.9	105.3	97.7	99.3
30-34	99.3	91.8	98.1	105.4	98.8	96.9
35-39	102.6	93.2	99.0	102.8	101.3	96.7
40-44	106.4	95.4	98.2	99.6	103.3	96.9
45-49	114.0	97.3	100.1	93.5	107.7	95.8
50-54	107.2	95.4	98.9	86.9	103.2	92.0
55-59	95.8	97.6	95.8	94.2	95.8	96.0
60-64	90.2	94.9	99.1	98.4	94.4	96.6
65-69	86.5	78.8	81.6	86.1	84.0	82.2
70-74	75.0	71.9	66.8	82.0	70.7	76.4
75+	61.7	57.9	58.5	54.1	59.9	56.1


Диаграмм 4.

**Хотын хүн амын хүйсийн харьцаа, насны бүлгээр /1989,2000 оны тооллогоор/**



Диаграмм 5.

**Хөдөөгийн хүн амын хүйсийн харьцаа, насны бүлгээр /1989,2000 оны тооллогоор/**



Дээрхи тоог оршин сууж буй газраар болон насны бүлгээр авч үзвэл 1989 онд манай орны хот суурин газрын хүн амын 0-14, 35-54 насныхны дунд эрэгтэйчүүд давамгайлж байсан бол 2000 онд зөвхөн 0-9 насныхнаас бусад нь эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин дийлэнх байсан нь харагдаж байна. Харин хөдөө орон нутагт бол 1989 оны байдлаар 0-30, 45-49 насны хүмүүсийн дунд эрэгтэйчүүд олон байсан бол 2000 онд энэ байдал өөрчлөгдөж 0-39 насны хүүмүүсийн дунд эмэгтэйчүүд цөөнх болж байсан байна.


Дээрхи тоонууд нь хүн амын дунд хүйсийн харьцаа алдагдсаны илрэл бөгөөд энэ бүхэн нь боловсрол дахь хүйсийн харьцаанд илрэлээ олсон нь зүй ёсны хэрэг юм.

**10, түүнээс дээш насны боловсролтой хүн амын эзлэх хувь, хүйс, насны бүлгээр /2000 оны тооллогоор/**

Насны бүлэг	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн ялгаа /эмэгтэй-эрэгтэй/	Бүгд
10-14	57.3	60.7	3.4	59.0
15-19	90.1	94.7	4.6	92.3
20-24	96.5	98.1	1.6	97.3
25-29	97.8	98.5	0.7	98.1
30-34	97.5	98.1	0.6	97.8
35-39	97.2	97.5	0.3	97.3
40-44	97.7	97.7	-	97.7
45-49	97.6	96.7	-0.9	97.2
50-54	97.2	95.4	-1.8	96.3
55-59	94.9	89.5	-5.4	92.3
60-64	91.2	82.8	-8.4	86.9
65-69	86.4	75.1	-11.3	80.2
70+	72.7	48.6	-24.1	58.0

Диаграмм 6.

**Боловсролтой хүн амын хүйсийн ялгаа, насны бүлгээр**



Үүний нэгэн тод жишээ бол манай оронд 2000 онд явагдсан тооллогын дүн /хүснэгт 4, диаграмм 6/ бөгөөд манай орны боловсролтой хүн амын хүйсийн харьцааг авч үзэх юм бол 10-19 нас буюу бүх шатны боловсролын байгууллагад хамрагдах насанд хүйсийн харьцаа хамгийн их ялгаатай “урвуу” буюу эмэгтэйчүүд давамгайлж байгаа нь харагдаж байгаа юм. Гэтэл 20-44 насанд хүйсийн ялгаа харьцангуй бага нь тухайн үед боловсролын хөгжлийн нөхцөл байдалтай шууд холбоотой юм. 1990 оноос өмнө манай оронд боловсрол үнэ төлбөргүй, улсын өмчийн сургуулиар дамжуулан улсаас бүрэн санхжүүлүүлэх үндсэн дээр хөгжүүлж байсан нь хүйсийн дээрхи харьцаанд нөлөө үзүүлсэн нь зүй ёсны хэрэг юм. 45-аас дээш насны хүмүүсийн дунд боловсролтой эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон байсан нь, тухайлбал 70-аас дээш насанд хүйсийн ялгаа хамгийн их буюу 24.1 пункт байгаа нь манай орны түүхэн хөгжил, тухайн үеийн нийгэм, улс төр, эдийн засгийн байдалтай холбоож үзэх үндэстэй.

**Хоёр. Судалгааны дүнгээс**

Манай орны боловсрол, тэр дотроо ерөнхий боловсролд жендерийн асуудал /хүйсийн харьцаа, тэгш эрхийн асуудал/ хэрхэн шийдэгдэж байгааг судлах зорилгоор ЮНЕСКО-гийн Ази, Номхон далайн орнуудын боловсрол дахь хүйсийн харьцааг судлах судалгааг манай орны нийслэл, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн ерөнхий

боловсролын сургуулийн 141 сурагч, 93 эцэг эх, 144 багш, удирдах ажилтны дунд явуулсан билээ.

Судалгаанд хамрагдсан аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдах 7-15 насны хүүхдийн хүйсийн харьцааг 2000 онд болж өнгөрсөн хүн амын тооллогын байдлаар авч үзэх юм бол дараахь тоо гарч байгаа юм /Хүснэгт 5/. Энэ насны хүүхдийн хүйсийн харьцц улсын дунджаар 6.1 пункт байхад судалгаанд хамрагдсан аймгуудад 2.7- 9.6 –ийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд хамгийн бага нь Улаанбаатар хот, хамгийн их ялгаа Өмнөговь аймагт байсан байна.

Хүснэгт 5.


**7-15 насны хүн амын сургуульд хамрагдалтын хувь, хүйсээр, 2000 оны тооллогоор /судалгаа явагдсан аймгаар/**

Аймаг, нийслэл	Хүйсийн ялгаа Эмэгтэй-эрэгтэй	Сургуульд хамрагдалтын хувь		
		эрэгтэй	эмэгтэй	Бүгд
БҮГД	6.1	77.6	83.7	80.6
Дорнод	7.1	73.6	80.7	77.1
Өвөрхангай	8.5	62.6	71.1	66.9
Өмнөговь	9.6	69.2	78.8	73.9
Ховд	5.3	73.4	78.7	76.0
Улаанбаатар	2.7	89.9	92.6	91.3

Сургуульд хамрагдалтын хувьд гэвэл 7-15 насны охидууд сургуульд хамрагдалтын хувь илүү байгаа нь харагдаж байна.

Диаграмм 7.

**7-15 насны хүн амын сургуульд хамрагдалтын хувь, хүйсээр, 2000 оны тооллогоор /судалгаа явагдсан аймгаар/**



2000 оны тооллогоос хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн, өнөөдөр манай орны боловсролд хүйсийн тэгш бус харьцаа байгаа эсэх, байгаа бол түүний шалтгаан, илэрч буй хэлбэр зэргийг судлан үзэхдээ бид боловсролын чанартай холбон үзсэн бөгөөд охид хөвгүүд чанартай боловсрол эзэмшихэд хүйсээр ялгаварлан үзэх үзэл манай оронд байгаа эсэхийг тодруулахыг эрмэлзсэн юм.


Ийнхүү судлагаагаа хийхдээ бид зөвхөн ерөнхий боловсролын сургуулийн суралцагсадын саналыг боловсролын үйлчилгээний гол хэрэглэгчид гэсэн утгаар нь өөрсдийнх нь санаа бодлыг анхааран үзээд зогсохгүй багш, боловсролын удирдах ажилтан, түүнчлэн багш, сурагчийн үйл ажиллагааны гол ажиглагч, хянагч, захиалагч болох эцэг эхийн санал бодлыг тусгахыг эрмэлзсэн болно.

Судалгааны ажлын гол знгилаа асуудал болох манай боловсролд хүйсийн тэгш бус харьцаа байгаа эсэх талаархи асуултанд сурагч, багш, удирдах ажилтан болон эцэг эхчүүд “Байгаа” гэж санал нэгтгэйгээр харилсан юм.


**Боловсролд хүйсийн тэгш бус харьцаа байгаа талаар**

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Байгаа	60,9	63,6	65,6	71	83,3	87,5
Байхгүй	21,2	22	8,6	13,1	13,2	9,3
Мэдэхгүй	17,7	24,6	21,5	5,2	2,8	3,2

Диаграмм 8.

**Боловсролд хүйсийн тэгш бус харьцаа байгаа талаар /хөдөө/**

Диаграмм 9.

**Боловсролд хүйсийн тэгш бус харьцаа байгаа талаар /хот/**

Санал асуулгад оролцогсад ийнхүү манай орны боловсролд хүйсийн тэгш бус харьцаа байгаа талаар санал нэгтгэйгээр дурьдсаны дотор багш, удирдах ажилтнууд оршин сугаа газраасаа үл харгалзан дээрхи хариултыг илүүтэйгээр буюу 83.3-87.5 хувь нь өгсөн нь энэ асуудал манай орны боловсролын шийдвэрлэвэр зохих тулгамдсан асуудлын нэг мөн гэдгийн гэрчилгээ юм.

Ийнхүү манай орны боловсролд хүйсийн тэгш бус харьцаа нь боловсролын бүх шатанд илрэлээ олж байгаа гэдгийг санал асуулгад оролцогсад бүгд дурьдсаны дотор бага, дунд боловсролыг онцлон тэмдэглэсэн байна /Хүснэгт 7/.


## Эмэгтэйчүүд илүүтэй ажиллаж буй боловсролын шат

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Сургуулийн өмнөх	20,6	32,4	65,6	73,6	70,1	59,3
Бага боловсрол	21,9	24,6	43	44,7	52,8	43,7
Дунд боловсрол	37,6	54,5	40,9	44,7	59,7	71,8
Дээд сургууль	18,4	24,6	10,7	7,8	11,8	3,1
Захиргааны байгууллага	2,1	14,3	7,5	5,2	0,7	0
Арга зүйн байгууллага	22,7	1,2	6,4	10,5	6,2	6,2

Жишээ нь, сургуулийн сурагчид дунд боловсролд эмэгтэйчүүд дамагйлж байна /хөдөөгийн сурагчдын 37,6%, нийслэлийн сурагчдын 54,6%/ гэж хариулсан нь тэдний хүрээлж буй орчиндоо хийсэн дүгнэлт гэж дүгнэж болно. Харин тэдний эцэг эх /хөдөөгийн эцэг эхийн 65,5%, хотын 73,6%/, багш, удирдах ажилтан /хөдөөд 70,1%, хотын 59,3%/ сургуулийн өмнөх боловсролд эмэгтэйчүүд дийлэнх байгааг дурьдсанаас гадна нийслэлийн багш, удирдах ажилтны 71,8% дунд боловсролд, 52,8% нь бага боловсролд эмэгтэйчүүд илүүтэй ажиллаж байна гэж үзжээ. Ийнхүү дунд боловсролыг онцлон тэмдэглсэн нь уг судалгаа ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд явагдсантай холбоотой гэж үзэх үндэстэй /Диаграмм 10,11/.


Диаграмм 10.

## Эмэгтэйчүүд илүүтэй ажиллаж буй боловсролын шат /хөдөө/



Диаграмм 11.

## Эмэгтэйчүүд илүүтэй ажиллаж буй боловсролын шат /хот/





Ийнхүү боловсролын салбарт эмэгтэйчүүд давамгайлж байгааг тэмдэглэхийн зэрэгцээ энэ байдал бий болсоны гол шалтгааныг судалгаанд оролцогсад дараахь байдлаар тайлбарлаж байна /Хүснэгт 8, диаграмм 12,13/.


Хүснэгт 8.

**Боловсролд эмэгтэйчүүд давамгайлж байгаагийн шалтгаан**

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Уламжлал	9,9	10,3	10,7	23,6	16,7	6,3
Санхүү, эдийн засгийн	27,6	24,6	25,8	21	31,3	62,5
Сэтгэл зүйн	56,7	35	57	44,7	43,7	31,2
Бусад	9,2	20,7	6,4	2,5	13,2	12,5


Диаграмм 12.

**Боловсролд эмэгтэйчүүд давамгайлж байгаагийн шалтгаан /хөдөө/**



Диаграмм 13.

**Боловсролд эмэгтэйчүүд давамгайлж байгаагийн шалтгаан /хот/**



Дээрхи хариултуудаас үзэхэд манай орны хөдөө орон нутагт суралцагч, тэдний багш, эцэг эхчүүд манай орны боловсролд эмэгтэйчүүд давамгайлж байгаагийн гол шалтгаан сэтгэл зүйд буюу эмэгтэй хүн илүү хүнлэг, энэрэнгүй, уян хатан байдаг гэсэн түгээмэл ойлголттой холбож үзсэн байна. Хот, суурин газрын сурагчдын эцэг эх тэдэнтэй санал нийлж байхад багш нар өөрсдөө хариулахдаа цалин хөлстэй холбоотой асуудлаас болж боловсролд өрх толгойлсон эрэгтэй хүн ажиллахад хүндрэлтэй гэж үзжээ. Ийнхүү эмэгтэйчүүд өнөөдөр боловсролын салбарын ажиллагсадын дийлэнх болж байгаагийн гол учир шалтгааныг манай орны санхүү эдийн засгийн байдал /боловсролын салбарт ажиллагсадын цалин хөлс/ болон нийгэмд хэвшмэл болсон сэтгэл зүйтэй холбож үзэж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Ийнхүү бага, дунд боловсролд илүүтэйгээр илэрч буй санхүү, эдийн засаг, сэтгэл зүйн шалтгааны улмаас бий болсон манай орны боловсрол дах хүйсийн тэгш

бус харьцаа нь гол төлөв багш, сурагчдын хүйсийн харьцаагаар илэрч байна /Хүснэгт 9, диаграмм 14,15/


Хүснэгт 9.

**Хүйсийн тэгш бус харьцаа илэрч буй хэлбэр**

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Сурагчдын хүйсийн харьцаа	41,8	38,9	38,7	71	45,1	50
Багш нарын хүйсийн харьцаа	27,6	35	51,6	42,1	64,6	84,4
Ажил, сургуульд орох тэгш бус эрх	28,4	31,1	21,5	5,2	11,1	9,4
Бусад	5	14,2	2,2	2,6	1,4	0


Диаграмм 14.

**Хүйсийн тэгш бус харьцаа илэрч буй хэлбэр /хөдөө/**



Диаграмм 15.

**Хүйсийн тэгш бус харьцаа илэрч буй хэлбэр /хот/**



Санал асуулгад оролцогсодын 38,9-71% нь өнөөдөр манай орны ерөнхий боловсролын сургуулийн нэг ангид суралцаж буй хүүхдийн хүйсийн харьцаа алдагдаж, охид давамгайлж байна гэж хариулсан бол 27,6-84,4% нь түрүүчийн асуултын хариултыг бататган ерөнхий боловсролын сургуульд эмэгтэй багш нар зонхилж байна гэсэн дүгнэлтийг хийжээ. Энэхүү хариултаудыг хот, хөдөөний судалгааны дүнгээр авч үзэх юм бол хот, хөдөөгийн сурагчдын

хариултууд нилээд ойролцоо байсан бол хот, суурин газрын эцэг эхчүүдийн үзэж байгаагаар дунд сургуулийн сурагчдын дунд охид дамгайлж байна /71% нь/ гэж үзсэн байхад хөдөөгийн эцэг эхчүүд багш нарын дунд эмэгтэй байгш нар олонхи /54,6%/ байгаагаар боловсрол дах хүйсийн тэгш бус харьцаа илэрч байна гэж үзжээ. Хот, хөдөөгийн багш, боловсролын удирдах ажилтны үзэж байгаагаар тэдний дунд эмэтэйчүүд зонхилж байгаагаар энэ салбар дах хүйсийн тэгш бус харьцаа илэрч байгаа ба энэ үзэгдэл хот суурин газарт илүүтэй /хотод 84,4%, хөдөөд 64,6%/ ажиглагдаж байна гэж тэмдэглэсэн байна. Үүний хажуугаар ажил, сургуульд ороход аль нэгэн хүйсэд давуу эрх ажиглагдаж байгааг санал асуулгад оролцогсод тэмдэглэснийг дурьдах хэрэгтэй. Хот суурин газар хүйсээр ялгаварлан ажил, сургуульд элсүүлж байгааг асуулгад оролцогсодын 5,2-31,1% хариулсаны дотор суралцагсад хамгийн их олноор тэмдэглэсэн байна. Хөдөөгийн оролцогсодын хувьд энэ асуултанд 11,1-28,4% хариулсны хамгийн олонг мөн л сурагчид хариулсан нь энэ үзэгдэл манай орны практик байна гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хүргэж байна.

Хэдийгээр манай орны боловсролд хүйсийн тэгш бус харьцаа нь дунд боловсролд байгаа гэдгийг бидний судалгаа харуулсан хэдий ч судалгааны үр дүнгээс харагдсан нэг чухал ололт бол манай орны чанартай боловсрол эзэмшихэд хүйсээр ялгаварлан үзэх үзэл байхгүй байна гэж санал асуулгад оролцогсод тэмдэглэсэн явдал юм /Хүснэгт 10, диаграмм 16,17/ .


Хүснэгт 10.

### Чанартай боловсрол ба хүйсээр ялгаварлан үзэх үзэл

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Тийм	27,6	18,2	15	21,8	10,4	9,4
Үгүй	47,2	53,2	67,7	68,4	81,3	78,1
Мэдэхгүй	22	33,7	15,1	10,5	11,1	12,5


Диаграмм 16.

### Чанартай боловсрол ба хүйсээр ялгаварлан үзэх үзэл /хөдөө/



Диаграмм 17.

### Чанартай боловсрол ба хүйсээр ялгаварлан үзэх үзэл /хот/



Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, тэдний эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид оршин суугаа газраасаа үл хамааран манай оронд чанартай боловсрол эзэмшихэд хүйсээр ялгаварлан үзэх үзэл байхгүй байгааг суралцагсадын 47,2-53,2%, тэдний эцэг эхийн 67,7-68,7%, багш, боловсролын удирдах ажилтны 78,1-81,3% -ийн хариулт хариулж байна. Гэвч санал асуулгад оролцогсодын 9,4-27,6% нь “байгаа” гэсэн хариулт өгсөн боловч өөрсдийнхөө хариултад ямар нэгэн үндэслэл гаргаж өгөөгүй нь зарим нэгэн тохиолдолд энэ төрлийн үзэгдэл ажиглагдаж байгаагийн илрэл гэж үзэж болно.

Энэ асуултын баталгаа болгож судалгааны явцад “Чанартай боловсрол эзэмших охид хөвгүүдийн эрмэлзлэл ялгаатай юу?” гэсэн асуултыг тавихад “Ялгаагүй” гэсэн харилт давамгайлж байв /Хүснэгт 11, диаграмм 18,19/.


Хүснэгт 11.

**Чанартай боловсрол эзэмших охид хөвгүүдийн эрмэлзлэл**

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Ялгаатай	17,7	9	19,3	13,2	25	31,3
Ялгаагүй	52,5	57,1	58	44,7	69,4	59,4
Мэдэхгүй	26,2	10,3	15,1	36,8	9	6,3


Диаграмм 18.

**Чанартай боловсрол эзэмших охид хөвгүүдийн эрмэлзлэл /хөдөө/**



Диаграмм 19.

**Чанартай боловсрол эзэмших охид хөвгүүдийн эрмэлзлэл /хот/**



Уг хариултууд дотор сурагчдын өөрсдийнх нь өгсөн хариулт болон тэдний багш, сурган хүмүүжүүлэгчдийн үзэл бодол онцгой анхаарлыг татаж байгаа бөгөөд тэдний “ялгаа байхгүй” гэсэн хариулт /52,5-69,4%/ оршин суугаа газраас ялгаваргүй байгааг судалгаа харуулж байна. Эцэг эхийн хувьд гэвэл хөдөө орон нутгийн эцэг эхийн хариулт тодорхой /“ялгаагүй” гэж 58% нь хариулсан/ байхад нийслэл хотын эцэг эхчүүд энэ асуудал дээр /“мэдэхгүй” гэсэн хариулт 36,8% байв/ эргэлзэх хандлага ажиглагдаж байна. Түүнчлэн хот суурин газрын багш, сурган хүмүүжүүлэгч, удирдах ажилтнууд чанартай боловсрол эзэмших охид, хөвгүүдийн эрмэлзлэл ялгаатай /31,3%/ гэж үзэж байгаагаа тэдний сурах хүсэл эрмэлзлэл, орчин, хувийн авьяас чадвар, аав ээжийн нөлөө зэрэгтэй холбон үзсэн байна.

Манай оронд өнөөдөр хүйсийн тэгш бус эрх байгаагийн нэгэн илрэл бол дунд боловсрол эзэмшихэд охид, хөвгүүдэд тусад нь зориулсан сурах бичиг, гарын авлага үгүйлэгдэж байгаа явдал юм. Бидний явуулсан судалгаа ийм төрлийн материал сургалтад тэр бүр хэрэглэгдэхгүй байгааг харуулж байна /Хүснэгт 12, диаграмм 20,21/.


Хүснэгт 12.

**Охид хөвгүүдэд зориулсан сурах бичиг, сургалтын материал хэрэглэгдэж байгаа байдал**

Хариулт	Хот	Хөдөө
Байнга	10	3,5
Заримдаа	6	19,8
Үгүй	84	66,6

Диаграмм 20.

**Охид хөвгүүдэд зориулсан сурах бичиг, сургалтын материал хэрэглэгдэж байгаа байдал**



Санал асуулгад оролцсон хүүхдүүдийн 66,6-84% нь охид хөвгүүдэд тусгайлан зориулсан сургалтын материалыг ашиглахгүй байгааг дурьдсан бөгөөд хөдөөгийн сурагчдын 19,3% нь “Зарим тохиолдолд ашигладаг”, нийслэлийн сурагчдын 10% “Байнга ашигладаг” гэж хариулсан нь тухайн хичээлийг зааж буй багшийн авьяас, сургалтын арга барилтай холбож үзэх үндэстэй.

Боловсролын хөгжлийн тулгамдсан асуудлын нэг бол хүний нөөцийн асуудал юм. Боловсролын салбарын хүний нөөцийн гол төлөөлөгч болсон багш нарын мэргэжил дээшлүүлэх асуудалд ч мөн адил жендерийн асуудал илрээлээ олдог нь дамжиггүй.

Бидний явуулсан судалгааны зорилтуудын дотор манай орны багш нарын мэргэжил дээшлүүлэх асуудалд хүйсээр ялгаатай хандах явдал байгаа эсэхийг судлах явдал байсан юм.

Багш, удирдах ажилтны дунд явуулсан судалгаанаас үзэхэд багш нарын мэргэжил дээшлүүлэх асуудал дээр хүйсэр ялгаварлан үзэх үзэл байхгүй байгааг харуулж байна /Хүснэгт 13, диаграмм 21/.


Хүснэгт 13.

**Багш нарын мэргэжил дээшлүүлэлт ба хүйсээр ялгааварлан хандах хандлага**

Хариулт	Хот	Хөдөө
Байнга	0	2
Заримдаа	4	11,8
Үгүй	96	89,5

Диаграмм 21.

**Багш нарын мэргэжил дээшлүүлэлт ба хүйсээр ялгааварлан хандах хандлага**



Судалгаанд оролцсон багш, удирдах ажилтны 89,5-96% нь мэргэжил дээшлүүлэх явдал хүйсээс үл хамааран ялгаваргүй, тэгш эрхтэйгээр хэрэгждэг гэдгийг тэмдэглэсэн нь манай орны боловсролын 70 жилийн түүхийн нэгэн ололт амжилтын нэг мөн гэсэн дүгнэлт хийх боломжийг олгож байгаа юм.

Энэхүү судалгаа нь зөвхөн боловсрол дахь хүйсийн тэгш бус байдлыг судлаад зогсохгүй өнөөдөр манай оронд чанартай боловсролын асуудлыг авч үзэх явдал байсан юм. Боловсрол дах жендерийн асуудал болон чанартай боловсрол хоёрыг бид түрүүнд чанартай боловсрол эзэмших тэгш эрх болон охид хөвгүүдийн эрмэлзлэл гэсэн үүднээс авч үзсэн бол чанартай боловсролд нөлөөлж буй ямар ямар хүчин зүйл байгааг сурагч, тэдний эцэг эх, багш, боловсролын удирдах ажилтны санал бодлоос авч үзсэн юм.


Хүснэгт 14.

**Чанартай боловсрол эзэмшихэд нөлөөлж буй хүчин зүйл**

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Эдийн засаг, санхүүгийн	46,8	46,7	61,3	78,9	60,4	59,3
Соёл, уламжлал	3,5	22	3,2	0	5,5	0
Нийгмийн хандлага	13,5	23,3	12,9	10,5	24,3	50
Боловсролын тогтолцоо	12,7	27,3	11,8	10,5	22,2	31,3
Сургалтын технологи, заах арга, багш	23,4	14,3	21,5	18,4	17,4	21,8
Сурах бичиг	25,5	16,9	12,9	15,7	15,3	25
Сургалтын орчин	24,1	35	19,3	34,2	31,3	37,5
Бусад	2,1	1,3	0	0	0,7	0

Диаграмм 22.


**Чанартай боловсрол эзэмшихэд нөлөөлж буй хүчин зүйл /хөдөө/**



Судалгаанд хөдөө орон нутгаас оролцогчид өнөөдөр чанартай боловсрол эзэмшихэд саад болж буй гол хүчин зүйлээр эдийн засаг санхүүгийн бэрхшээл гэж нэрлэжээ. Сурагчдын 59,3%, тэдний эцэг эхийн 78,9%, багш, удирдах ажилтны 46,7% нь санхүүгийн боломжоос хамааран чанартай боловсрол эзэмшихэд хүндрэл учирч байгааг тэмдэглэсэн нь өнөөдөр манай оронд чанартай боловсрол зөвхөн бэл бэнчинтэй хүнд л хүртээмжтэй болж, төлбөртэй боловсрол л чанартай гэсэн ойлголт бий болсоны илрэл юм. Түүнээс гадна багш, удирдах ажилтны 50% нь нийгмийн зүгээс боловсрол хандах хандлага таагүй, сургалтын орчин /хичээлийн болон дотуур байр, сургуулийн материаллаг бааз, мэдээллийн хангамж дутмаг байгаагаас /багш нарын 37,5%, эцэг эхчүүдийн 34,2%/ хүүхдэд чанартай боловсрол олгож чадахгүй байна гэж дурьдсан нь хөдөө орон нутагт энэ асуудалд төр засгийн зүгээс анхаарал хандуулахыг шаардаж байна.

Диаграмм 23.

**Чанартай боловсрол эзэмшихэд нөлөөлж буй хүчин зүйл /хот/**



Хот суурин газар амьдарч байгаа хүмүүсийн хувьд мөн адил чанартай боловсрол эзэмшихэд саад болж буй гол шалтгаан нь эдийн засаг, санхүүгийн хүчин зүйл юм гэж дурьджээ. Сурагчдын 46,8%, багш нарын 60,4%, эцэг эхийн 61,3% энэ хүчин зүйлийг дурьдсан нь боловсролын чанарын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж арга хэмжээ авах шаардлага бий болсоныг харуулж байна.


Өнөөдөр манай оронд боловсролын чанарыг дээшлүүлэхэд чухам хэний хүчин чармайлт шаардлагатай байгааг судалж үзэхэд дарахь дүр зураг ажиглагдаж байна. /Хүснэгт 15/

## Боловсролын чанар ба хүчин чармайлт

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Төр засгийн	29,1	51,9	45,2	71	56,3	68,7
Орон нутгийн	5	1,3	10,7	23,7	12,5	6,3
Багшийн	38,3	35,1	40,9	68,4	42,4	50
Эцэг эхийн	7,8	9	25,8	26,3	29,9	53,2
Сурагчдийн	37,6	38,9	25,8	42,1	46,5	53,2
Олон нийтийн	10,6	11,7	6,5	0	8,3	3,2

Диagramм 24.


## Боловсролын чанар ба хүчин чармайлт/хөдөө/



Хөдөө орон нутагт боловсролын үйлчилгээ үзүүлж, түүгээр үйлчлүүлж байгаа хүмүүсийн үзэл бодлоо өнөөдөр манай оронд боловсролын чанарыг дээшлүүлэхэд нэн тэргүүнд төр засгийн хүчин чармайлтыг чухалыг багш, удирдах ажилтны 56,3%, эцэг эхийн 45,2% онцлон тэмдэглэсэн байна. Түүнчлэн манай орны багш, сурган хүмүүжүүлэгч боловсролын чанарыг дээшлүүлэхэд өөрсдийнх /42,4%/ болон сурагчдынх нь /46,5%/ хүчин чармайлт /42,4%/ шаардлагатай байгааг ухамсарлаж байгааг судалгаа харуулсан бөгөөд эцэг эхчүүд ч мөн тэдэнтэй санал нэгтэй /40,9%, 25,8% тус тус / байна. Гэтэл сурагчдын үзэл бодлоор бол төр засаг /29,1%/ болон эцэг эхчүүдэд /37,6%/ гол ачааг үүрүүлж байгаа нь бэлэнчлэх сэтгэлгээний үүднээс боловсролд хандаж байгаагийн илрэл юм.

Диagramм 24.

## Боловсролын чанар ба хүчин чармайлт /хот/





Хот суурин газраас энэ асуултанд хариулсан байдлыг авч үзэх юм бол мөн адил төр засгийн хичээл зүтгэлийг /багш, удирдах ажилтны 68,7%, эцэг эхийн 71%, сурагчдын 53,3%/ дурьдсан бөгөөд багш, эцэг эх, сурагчдын хамтын ажиллагаа, хүчин чармайлт ч чухал байгааг тэмдэглэсэн байна. Жишээлбэл, багш нарын идэвх санаачлагын чухалыг багш, удирдах ажилтны 68,4%, эцэг эхийн 50%, эцэг эхийн оролцоог багш нарын 53,2% онцлон тэмдэглэсэн байхад багш нарын 53,2%, эцэг эхийн 42,1% нь сурагчид ч энэ үйл хэрэгтэй хувь нэмрээ оруулах ёстой гэж үзжээ. Суралцагсадын хувьд төр засаг, багш, сурагчид өөрсдөө хамтран үр ашигтай ажилласнаар боловсролын чанарыг дээшлүүлэх боломжтой гэж үзсэн нь хот суурин газар ерөнхий боловсрол эзэмшиж буй хүүхдүүд өөрсдийнхөө үүргийг ойлгож боловсролд хандах хандлага нь харьцангуй дээшилж байгааг харуулж байна. Түүнчлэн хот, хөдөөгийн хариултуудаас үзэхэд боловсролын чанарыг дээшлүүлэхэд орон нутгийн оролцоог онцгойлон авч үзээгүй нь боловсролын орон нутгийн удирдлагын үйл ажиллагаа хангалтгүй байна.

Боловсролын чанарын нэг үзүүлэлт бол боловсролын үйлчилгээний чанар чансаа, эрэлт хэрэгцээг хангаж байгаа явдал байдаг. Энэ суудлыг судлах үүднээс сурагчдаас сургууль дээр явагдаж байгаа сургалт тэдний хэрэгцээг хэрхэн хангаж байгаа, багш нараас тэдний үйл ажиллагаа сурагчдын хэрэгцээг хангаж чадаж байгаа эсэхийг судалж үзсэн болно /Хүснэгт 16/. Хот хөдөөгийн сурагчдын үзэж байгаагаар өнөөдөр манай орны ерөнхий боловсролын сургууль дээр явагдаж буй сургалт тэдний боловсролын хэрэгцээг боломжийн түвшинд хангаж байна гэж үзсэн байхад хөдөөгийн багш нарын үнэлгээ сурагчдынхаас харьцангуй доогуур байгаа нь багш нар өөрсдийнхөө мэдлэг чадвар, ажлын нөхцөл байдалд шүүмжтэй хандаж байгаагийн илрэл гэж үзэж байна.

Хүснэгт 16.

#### Сургалтын эрэлт хэрэгцээг хангаж байгаа байдал

Асуулт/Хариулт	Хот	Хөдөө
<i>Сурагчид:</i>		
Сайн хангадаг	13	4,8
Боломжийн	45	32,6
Тийм ч сайн биш	39	46
Хангаж чаддаггүй	12	10,6
<i>Багш нар</i>		
Сайн хангадаг	3,1	1,4
Боломжийн	40,6	59
Тийм ч сайн биш	37,5	42,3
Хангаж чаддаггүй	15,6	2,8

Хариултуудаас үзэхэд хот хөдөөд боловсролоор үйлчлүүлэх гэсэн сурагчдын эрэлт хэрэгцээ харьцангуй ижил түвшинд байгаа хэдий ч хөдөө орон нутагт доогуур /"тийм ч сайн биш" – 46%/ байгаа нь хөдөө орон нутагт чанартай боловсрол эзэмших бололцоо ялгаатай байгаагийн нэгэн илрэл юм. Багш нарын хувьд ч мөн адил "сайн хангадаг" гэсэн хариулт бага байгаа нь эрэлт хэрэгцээг зохих хэмжээнд хангаж чадахгүй байгааг харуулж байна.

Манай оронд хот суурин газар болон хөдөө орон нутагт чанартай боловсрол эзэмшихэд ялгаа өндөр байгааг бидний явуулсан судалгаа харуулж байна /Хүснэгт 17/.


Хүснэгт 17.

#### Чанартай боловсрол эзэмшихэд хот, хөдөөгийн ялгаа байгаа талаар

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот
Тийм	82,2	79,2	87,1	89,5	83,3	93,8
Үгүй	7,1	18,2	7,5	5,3	14,6	3,1
Мэдэхгүй	10,6	2,6	3,2	10,5	4,9	3,1

Диаграмм 25.

**Чанартай боловсрол эзэмшихэд хот, хөдөөгийн ялгаа байгаа талаар**



Хөдөөгийн сурагч, тэдний эцэг эх, багш, удирдах ажилтны 82,2-83,3%, хот суурин газрын оролцогсодын 79,2-93,8% чанартай боловсрол эзэмшихэд хот, хөдөөгийн ялгаа байгаа гэдгийг дурьдсан нь нэг талаас өнөөдөр манай орны ерөнхий боловсролын чанар газар зүйн байршиллын хувьд ялгаатай байгааг харуулж байгаа бөгөөд нөгөө талаас зөвхөн мэдээлэл, үйлдвэрлэл, үйлчилгээ төвлөрсөн хот суурин газар чанартай боловсрол эзэмших боломж байгааг харуулж байна.

Хөдөө орон нутагт чанартай боловсрол эзэмшихэд саад тотгор болж буй хүчин зүйлийн дотор сургалтын орчин буюу хичээлийн болон дотуур байрны тав тухтай таатай бус орчин багтаж байгаа нь өнөөдөр манай орны боловсролд шийдвэрээ хүлээж буй асуудлуудын нэг гэдгийг бидний хийсэн судалгаа харуулж байна. Өмнөговь, Ховд, Өвөрхангай, Дорнод аймаг, Улаанбаатар хотод хийсэн судалгаанаас үзэхэд дотуур байр дулаан хэдий ч тавлаг байж чадахгүй байгааг судалгаа харуулж байна /хүснэгт 18/.

Хүснэгт 18.

**Дотуур байр**

Асуулт/Хариулт	Хот	Хөдөө
<i>Дулаан эсэх:</i>		
Тийм	70	60,9
Үгүй	30	17,7
<i>Тавлаг байдал</i>		
Тийм	11	31,3
Үгүй	89	62,5

Санал асуулгад оролцогсадын 60,9-70% нь дулаан дотуур байранд амьдардаг хэдий ч 62,5-89% нь амьдрах таатай бус байранд сууж байгаа нь боловсролын чанарыг дээшлүүлж, сурагчдад сурч амьдрах таатай нөхцөл бүрдүүлэх асуудал дээр анхаарлаа хандуулах нь тулгамдсан асуудлын нэг болж байгааг харуулж байна.

1990-ээд онд манай улс зах зээлд шилжин орсонтой холбогдуулан сургууль завсардалт нэмэгдэж байсан бол өнөөдөр нийгэмд боловсролд хандах хандлага өөрчлөгдөн байдал нааштайгаар эргэж байгаагийн илрэл бол сургуульд завсардсан хүүхдүүд сургуульдаа эргэн орж байгаа явдал юм /Хүснэгт 19/.

Хүснэгт 19.


**Сургууль завсардсан хүүхдүүд эргэж сургуульдаа ороход хүйсийн ялгааны талаар**

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Охид	38,6	36,2	60	34,4	18,2	31,2
Хөвгүүд	5,7	8,5	5,7	7,5	22,7	13,9
Ялгаагүй	55,7	52,5	34,3	51,6	59,1	61,1

Өнөөдөр сургуульдаа эргэн орж байгаа хүүхдийг хүйсээр ангилан авч үзэх юм охид, хөвгүүд хот, хөдөөд адил түвшинд эргэн орж байна.


Диаграмм 26.

**Сургуульд эргэж орж буй хүүхдийн хүйсийн ялгаа /хот/**



Диаграмм 27.

**Сургуульд эргэж орж буй хүүхдийн хүйсийн ялгаа /хөдөө/**



Тэдний ийнхүү сургуульдаа эргэж орж буй шалтгааныг бид ангилж үзэхэд дараахь дүр зураг ажиглагдаж байна /Хүснэгт 20/.

Хүснэгт 20.


**Хөвгүүд сургуульд эргэж орж байгаагийн шалтгаан**

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Эцэг эхийн шаардлага	56,5	41,1	69,4	25,8	40	38,9
Анги хамт олны нөлөө	17,1	13,4	5,5	3,2	4	4,9
Удирдлагын шаардлага	1,3	12,1	2,7	12,9	12	11,1
Өөрийн хүсэлтээр	25	41,1	22,2	41,9	44	43,8

Өөрөөр хэлбэл эцэг эхийн хүсэлт, шаардлагаар /25,8-69,4%/ болон өөрсдийнхөө мэдлэг боловсролоо үргэлжлүүлэн дээшлүүлэх гэсэн /22,2-41,9%/ эрмэлзлэлд хөтөлгөдөн сургуульдаа эргэн орж байна.

Диаграмм 28.


**Хөвгүүд сургуульд эргэж орж байгаагийн шалтгаан /хот/**



Хүйсээр авч үзэх юм бол сурагч, эцэг эх, багш нарын үзэж байгаагаар хот суурин газрын хөвгүүд ихэвчлэн эцэг эхийн шаардлагаар /40-60,4%/ эргэж сургуульдаа орж байхад багш нар мөн сурагчид өөрсдөө хүсэлтээрээ /44%/ сургуульдаа орж байна.

Диаграмм 29

**Хөвгүүд сургуульд эргэж орж байгаагийн шалтгаан /хөдөө/**



Хот суурин газар бол хөвгүүд өөрсдөө саналаараа сургуульдаа орох нь илүүтэйг /41,1-43,8%/ бүгд онцлон тэмдэглэхийн зэрэгцээ хөвгүүд сургуульдаа эргэж ороход эцэг эх чухал үүрэг гүйцэтгэж байгааг /25,8-41,1%/ дурьдсан байна.

Охид сургуульдаа эргэж орж байгаа байдлын хувьд бол харьцангуй өөр дүр зураг ажиглагдаж байгаа юм. Охид сургуульдаа эргэн ороход эцэг эхийн үзэж байгаагаар анги хамт олны нөлөө /ялангуяа хот суурин газар 66,6%/ чухал үүрэг гүйцэтгэж байна. Хөдөө орон нутагтай нэгэн адил охид сургуульдаа эргэж ороход эцэг эхийн шаардлага /39,4-45,6%/ болон өөрсдийнх нь хүсэл эрмэлзлэл /40,6-63,8%/ чухал байгааг санал харуулж байна.

Хүснэгт 21.

**Охид сургуульдаа эргэн орж байгаагийн шалтгаан**

Хариулт	Суралцагсад		Эцэг эх		Багш, удирдах ажилтан	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Эцэг эхийн шаардлага	45,6	33,3	39,4	33,3	43,4	35,4
Анги хамт олны нөлөө	10,4	7,1	66,6	2,1	0	4,2
Удирдлагын шаардлага	0	5,7	5,3	5,4	5,3	8,3
Өөрийн хүсэлтээр	49,3	63,8	52,6	44,1	40,6	63,8

Энэ бүхнээс дүгнэлт хийхэд өнөөдөр боловсролын үнэ цэнэ, ач холбогдлыг нийгэм, хувь хүний зүгээс үнэлэх үнэлэмж өөрчлөгдөж байгаагийн илрэл бол эцэг эхийн зүгээс хүүхдийнхээ мэдлэг боловсролд тавих анхаарал нэмэгдэж, хүүхэд өөрөө үргэлжлүүлэн суралцах хүсэл эрмэлзлэл нэмэгдэж байгаа явдал юм.

Эмэгтэй сурагчид сургууль завсардаж, сургуульдаа эргэж орохтой холбоотой нэгэн асуудал бол жирэмслэх явдал юм. Бидний явуулсан судалгааны хүрээнд энэ асуудлыг судалж үзэхэд ерөнхий боловсролын сургуульд суралцах явцдаа жирэмслэх тохиолдол байгаа бөгөөд жирэмсэн сурагчид үргэлжлүүлэн сурах бололцооны талаар багш, сурагчид өөрсдөө бүрхэг ойлголттой байгаа нь харагдаж байна /Хүснэгт 22/.

Хүснэгт 22.

### Жирэмсэн сурагчид ба үргэлжлүүлэн суралцах бололцоо

Асуулт/ хариулт	Сурагч		Багш, удирдах ажилтан	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
<i>Сургуульд жирэмсэн сурагч байгаа эсэх:</i>				
Байгаа	40,3	20,7	53,1	26,3
Үгүй	10,3	24,2	6,2	21,5
Мэдэхгүй	51,9	51	37,5	36,8
<i>Тэдэнд үргэлжлүүлэн сурах боломж байгаа талаар</i>				
Тийм	18,2	23,4	28,1	35,4
Үгүй	15,5	7,8	15,6	17,3
Мэдэхгүй	66,3	12	46,8	9

Хариултуудаас үзэхэд хэдийгээр жирэмсэн охид байгаа гэдгийг багш /26,3-53,1%/, сурагчид /20,7-40,3%/ хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч дийлэнх нь энэ талаар ямар ч мэдээлэлгүй /36,8-51,9%/ байгаагаас гадна жирэмсэн сурагчид үргэлжлүүлэн суралцах бололцооны талаар хот суурин газрын багш, сурагчид /66,3%, 46,8% тус тус/ ямар ч ойлголтгүй байгаа нь нэгийг бодогдуулж байна.

### Гурав. Дүгнэлт.

Манай орны ерөнхий боловсролын хүрээнд боловсрол дах жендерийн асуудлыг авч үзсэн дээрхи судалгаанаас дараах дүгнэлтийг хийж болно. Үүнд:

1. Манай орны боловсролд хүйсийн тэгш бус харьцаа байгаагаас гадна багш, сурагчдын хүйсийн харьцаагаар илэрч байгааг энэхүү судалгаа баталсан бөгөөд энэ нь хүн амын дундах хүйсийн тэгш бус харьцааны нэгэн илрэл юм.
2. Өнөөдөр манай оронд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын эмэгтэйчүүд давамгайлж байгааг судалгаа харуулж байна.
3. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролд ийнхүү эмэгтэйчүүд давамгайлж байгаагийн гол шалтгаан нь нийгэм, хүн амын дунд түгээмэл болсон “эмэгтэй багш – хамгийн сайн багш” гэсэн ойлголт болон багшийн цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой санхүү мөнгөний асуудалд байгаа тул өрх толгойлсон эрэгтэйчүүд энэ салбарт ажиллах сонирхолгүй байгааг харуулж байна.
4. Судалгаанд оролцогсод ажил, сургуульд элсэн ороход хүйсээр ялгаварлан үзэх үзэл байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
5. Хүйсийн хувьд чанартай боловсрол эзэмших тэгш эрх хөдөө, орон нутагт адил хэмжээгээр хангагдаж байгаа хэдий ч өнөөдөр манай орны практикт чанартай боловсрол эзэмшихэд хот, хөдөөгийн ялгаа байгааг судалгаанаас харагдаж байгаа нь хөдөөгийн боловсролыг хөгжүүлэн, мэдээлэл, материаллаг баазыг нь бэхжүүлэх шаардлагыг гарган тавьж байна.
6. Сургууль завсардсан хүүхэд сургуульдаа эргэж орох, чанартай боловсрол эзэмших гэсэн эрмэлзлэл охид хөвгүүдийн хувьд адил байгаа бөгөөд хүүхдийнхээ мэдлэг боловсролыг үргэлжлүүлэхэд эцэг эхийн хүсэлт, шаардлага, сурагчдын өөрсдийнх нь эрмэлзлэл их байна гэж судалгаанд

оролцогчид үзсэн хэдий ч өнөөдөр манай оронд чанартай боловсролыг охид, хөвгүүд адил хэмжээгээр эзэмшихэд саад болж буй нэгэн асуудал бол охид, хөвгүүдэд тусад нь зориулсан сурах бичиг, гарын авлага дутмаг байгаа явдал юм.

7. Боловсролын хөгжлийн чухал асуудлын нэг болох багш нарын мэргэжил дээшлүүлэх асуудалд хүйсээр ялгаварлан үзэх үзэл үндсэндээ байхгүй байгаа нь нийгэмд хүйсээр ялгаварлан үзэх үзэл үгүй байгаагийн илрэл гэж үзэж болно.
8. Боловсролын чанарыг дээшлүүлэхэд төр засгийн хүчин зүтгэлээс гадна сурагч, эцэг эх, багшийн өөрсдийнх нь хүчин чармайлт чухал гэдгийг ойлгож байгаа нь боловсролын чанар бол хамтын ажиллагааны үр дүн гэдгийг боловсролоор үйлчлүүлэгчид ойлгож нийгэмд боловсролд хандах хандлага өөрчлөгдсөний жишээ юм.